



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/217

Номгон


Аймгийн Онцгой комиссын
Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны асуудал
хариуцсан шуурхай бүлэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27¹.1.6, 32.1.1, аймгийн Засаг даргын 2021 оны “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгах тухай” 02, “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/216 дугаар захирамж, аймгийн Онцгой комиссын 2021 оны 30 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст цар тахлын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд аймгийн Онцгой комиссоос авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллийг нэгдсэн нэг сувгаар мэдээлэлж, иргэд олон нийтийг албан ёсны мэдээллээр хангах аймгийн Онцгой комиссын Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны асуудал хариуцсан шуурхай бүлгийг томилсугай.

2.Аймгийн Онцгой комиссын Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны асуудал хариуцсан шуурхай бүлгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.




ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

1210543

Аймгийн Засаг даргын 2021 оны 03
дугаар сарын 26-ны өдрийн 217 дугаар
захирагжийн хавсралт



АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ,
СУРТАЛЧИЛГААНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН
ШУУРХАЙ БҮЛГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Шуурхай бүлгийн
дарга
Гишүүд

Онцгой комиссын нарийн бичгийн дарга

Эрүүл мэндийн газрын дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл
мэдээллийн төлөөлөгч
Телевизүүд

_____оОо_____